

хэн ухаарч, харин нийгмийн хувьсгалууд, хувьсгалын эсэргүү явдал ч дараалалт шинжтэйд дасал болжээ.

1993. 5 сар

**МОНГОЛ ОРОНД ТОТАЛИТАР
ДЭГЛЭМ НОЁРХСОН ЗАРИМ
АСУУДАЛ**

А. Жамбал*

I

Тоталитаризм хэмээх улс төрийн дэглэм, ноёрхлын өвөрмөц онцлогтой шинэ хэлбэр нь ХХ зууны 20-иод оны үеэс ЗХУ-д большевикуудын коммунист дэглэм буюу зүүн хэлбэрээр, Итали, Герман зэрэг орнуудад фашизм буюу баруун хэлбэрээр анх үүсэн тогтжээ. Тоталитаризмын - үзэл санаа, үзэл суртлын эх үүсвэр, үндсийг баруун талаас нь Жентиле, Муссолини, Гитлер, Розенберг нар, зүүн талаас нь Л. Троцкий зэрэг зүүн коммунизмын үзэл сурталчид үндэслэн тавьсан гэж судлагчид үздэг байна. Үүний зэрэгцээ зүүн буюу большевик маягийн тоталитаризмын үзэл санаа, үзэл суртлын эх үндэс нь сталинизм гэдгийг тэмдэглэх хэрэгтэй.

Тоталитаризмын асуудлыг судалдаг дэлхий нийтийн эрдэмтэн мэргэжилтнүүд уг үзэгдлийг авч үзэж шинжлэхдээ үндсэндээ барууны орнуудын, нэн ялангуяа тоталитаризмын судалгааны ихээхэн өв уламжилтай Герман, Америкийн эрдэмтдийн үзэл баримтлал, үнэлэлт дүгнэлтийг онол, арга зүйн үндэс, чиглэл болгодог байна.¹

Тоталитаризмын мөн чанарыг нээн илрүүлж үнэн зөв ухааран ойлгоход улс төрийн дэглэм хэмээх ойлголт чухал үүрэг гүйцэтгэнэ.

Улс төрийн дэглэм бол тухайн улс орон дахь улс төрийн ардчилал, хүний эрх, эрх чөлөө, төр ба иргэний нийгмийн хоорондын харилцааны нийгэм-улс төрийн шинж чанар, төлөв байдал юм. Энэ утгаар үзвэл тоталитаризм бол иргэний нийгэм, бие хүний амьдралыг хүнд сурталт, цэрэгжсэн төр бүхэлд нь хатуу дэглэн захирсан, улс төрийн ардчилал, хүний эрх, эрх чөлөөг үгүйсгэдэг улс төрийн дарангуй дэглэм юм.

Тоталитаризм чухамдаа ХХ зууны шинэ үзэгдэл бөгөөд тэрээр хүн төрлөхтний түүхэнд гарч ирж ноёрхож байсан улс төрийн дарангуйллын хэрцгий дэглэм (тирания) дур зоргоор дарангуйлах ёс (деспотия), диктатур болон бусад хэлбэрүүдээс хэд хэдэн шинжээрээ ялгардаг. Улс төрийн уламжлалт дарангуй дэглэмүүд өөрийнхөө ноёрхлоо нийгмийн хэвшиж тогтсон уламжлалт байгуулал, хүрээ хязгаарын дотор тогтоон барьдаг бол тоталитаризм нийгмийн тэрхүү уламжлалт байгуулал, эдийн засгийн хэвшил, оюуны уламжлалт соёл, үнэт зүйлсийг эвдэж түүний нуранган дээр цоо шинээр бүтээн босгохыг чухалчилдаг ажээ. Энэ нь ялангуяа зүүн хэлбэрийн тоталитаризм буюу социалист, коммунист дэглэмийн имманент чанар нь болдог байна. Өмнөх үеийн улс төрийн уламжлалт дэглэмүүд хүнийг дарангуйлан ноёрхохдоо түү-

* ШУА-ийн Философи, социологийн хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтан

нийг нийгмийн бүтэц, байгууллагуудтай холбогдсон хэлхээ холбооных нь хүрээнд, өөрөөр хэлбэл гэр бүл, овог аймаг, ястан үндэстэн, нутаг ус, сүм хийд, уламжлал, ёс заншилтай нь холбоотой байлгадаг байсан бол тоталитаризм хүнийг эдгээр жам ёсны хэлхээ холбооноос нь салгаж зөвхөн төр, дарангуйлагч намтай холбож, зөвхөн энэ хоёрт л үнэнч байж шүтэн биширдэг болгохыг зорьдгоороо онцлогтой. Тоталитаризмын өөр нэг онцлог бол тэрээр гадаад ертөнцөд харьцангуйгаар хаалттай, битүү, тусгаарлагдсан байдаг явдал болно.

Тоталитаризмын асуудлаар одоогоор хийсэн судалгааны зарим үр дүнд тулгуурлаж тоталитар дэглэмийн бүтцийн гол бүрдэл хэсэг, үндсэн шинж бол 1. бүхнийг хамарсан албан ёсны цорын ганц үзэл суртал; 2. эл үзэл суртлыг номлон хэрэгжүүлэгч улс төрийн ноёрхогч ганц нам; 3. Цэрэгжин цагдаажсан төр, түүний хүнд сурталт нүсэр аппарат; 4. засгийн бүх эрх мэдлийг зүй бусаар булаан авч гартаа төвлөрүүлсэн «агуу их жолоодогч, удирдагч» хэмээгдэн өргөмжлөгдсөн дарангуйлагч; 5, хүчирхийлэл, хэлмэгдүүлэлт, аллага хядлагын зохион байгуулалттай тогтолцоо; 6. удирдлагын туйлын төвлөрөл; 7. оюун санаа соёлын хүрээ, мэдээллийн хэрэгсэлд тогтоосон төрийн хатуу хяналт, онц эрх хэмээн үзэж болмоор байна.

II

Монголын ард түмний XX зууны эхэн үеэс өрнөсөн үндэсний эрх чөлөө, тусгаар тогтнолын төлөө тэмцэл нь 1911, 1921 онд тус бүртээ чухал үр дүнд хүрсэн бөгөөд тэдгээр нь зүй нь улс үндэсний сэргэн мандалтын цаашдын өрнөлтийн эхлэл, суурь болох ёстой байв. Гэвч тэгсэнгүй, үйл явдлын цаашдын өрнөлт бүхэлдээ большевикуудын дэглэм тогтсон Орос гүрний шууд нөлөөн доор явагдах болжээ.

Монголчууд 1921 оны хувьсгалаар үндэсний эрх чөлөө, тусгаар тогтнолоо олж авч, энэ хэрэгт Зөвлөлт Орос улсаас цэрэг-улс төрийн тусламж дэмжлэг үзүүлэхдээ Монгол оронд өөрийн орны улс төрийн дэглэм, үзэл номлолыг хүлээн зөвшөөрүүлэх, дагаж мөрддөг болгох нөхцөл, болзлыг давхар тооцож хангасан байв. Энэ байдалтай уялдаж Монгол дахь 1921 оны хувьсгал барагцаалбал, 1924 он хүртэл тус орны өвөрмөц байдал, онцлогийг ямар нэг хэмжээгээр тусгаж уян хатан арга ажиллагаа, хэлбэрээр өрнөжээ. Гэхдээ хувьсгалт үйл явц эхнээсээ аваад ангийн зорилго, шинж чанараа хадгалан нийгмийн ядуу хэсэг давхрааны эрх ашгийг хамгаалж, хуучны ноёлогч хэсэг, давхрааны эсрэг чиглэн явсан юм. Энэ чиг шугам цаашдаа улам лавшран гүнзгийрсэн бөгөөд түүний үргэлжлэл болж яваандаа Монгол оронд тоталитар дэглэм тогтоход хүргэсэн улс төрийн хэд хэдэн шийдвэр, зорилгыг 1924 онд хуралдсан МАН-ын III их хурлаас гаргаж хэрэгжүүлэх болжээ. Тэдгээрийн нэг нь тус орныг капиталист биш замаар буюу социализмыг чиг баримжаа болгон хөгжүүлэх тухай зүүн социализмын улс төрийн жанжин шугам бүхий зорилго байв. Угаасаа биелэгдэх үндэсгүй, тэр тусмаа феодализмын хоцрогдмол буурай орон байсан Монголд тийм зорилго дэвшүүлэн тавьж түүнийг хэрэгжүүлэх зорилгоор улс төр, үзэл суртлыг гол хэрэгсэл болгон ашиглаж, удирдлага, хяналт, хүч нөөц бүхнийг улам бүр төвлөрүүлэн чангалж дайчилсан явдал тоталитар дэглэм тогтох суурь дэвсгэр, хүчин зүйлийг бэлтгэн бий болгожээ.

Тухайн үедээ манайд цорын ганц байсан МАН-ыг цаашдаа нийгмийн амьдралд ноёрхогч, засгийн эрхийг дангаараа барьсан улс

төрийн онцгой хүч болгож дархлах зорилгоор тус намын III-р их хурлаас монгол оронд МАН-аас өөр улс төрийн нам гаргахгүй байвал зохино гэсэн шийдвэр гаргаж түүнийг нийгэмд тулган хүлээлгэсэн юм. Энэ нь тус оронд улс төрийн олон эшт ургалч үзэл, байр суурь гаргахыг албан ёсоор хориглож улс төрийн ардчилал хумигдсан хэрэг байв. Дараа жил буюу 1925 онд хуралдсан МАХН-ын IV-р их хурлаар баталсан намын дүрэмд марксизм-ленинизмыг намын үйл ажиллагааны удирдлага мөн гэж зааж тусгасан явдал хэрэг дээрээ марксизм-ленинизмыг намаар дамжуулж тус орон дахь албан ёсны цорын ганц үзэл суртал болгон өргөмжилсөн хэрэг байв.

Тоталитар дэглэм үүсэн тогтоход түлхэц өгдөг өөр нэг ноцтой үйлдэл энэ үед давтагдах болсон бөгөөд тэр нь улс төр, үзэл суртлын хувьд өөр байр суурь баримталж, өөрөөр бодож сэтгэх явдлыг МАХН-ын зүгээс зүгээр нэг хориглон эсэргүүцэх төдийгүй холбогдох хүмүүс, удирдах зүтгэлтэнгүүдийг хилсдүүлэн алж устгадаг болсон явдал юм. Монгол оронд большевикуудын шууд оролцоотойгоор дөнгөж төрөн гарч буй улс төрийн шинэ дэглэм аллага хядлагын анхны туршилтын алхам, эхлэл болгож бүр 1922 онд Бодоог, 1924 онд Данзанг улс төр, үзэл суртлын өөр байр суурь, үзэл бодлынх нь хариу болгож хилс дүүлэн цаазалжээ.

Оросын большевикууд, коминтерны нөлөө шахалтаар МАХН-аас баримтлан хэрэгжүүлэх болсон хөгжлийн капиталист биш зам буюу социалист чиг баримжаа нь нийгэмд томоохон эмгэнэлт үр дагавруудыг бий болгосны өөр нэг ноцтой нь гэвэл нам, төрийн зүгээс нийгмийн өмч хөрөнгөтэй, идэвхтэй, үйлдвэрлэн бүтээгч хэсгийг, түүнчлэн шашны эрдэм боловсролтой, оюуны уламжлалт соёлыг эзэмшин хадгалсан хэсэг болох лам нарыг эхлээд эдийн засгийн талаас нь довтолж, дараа нь үүний улмаас гарсан тэдний зүй ёсны эсэргүүцэл тэмцлийг шалтаг болгож багагүй хэсгийг нь хүчирхийлэн устгасан явдал юм. МАХН-ын зүгээс нийгмийн анги бүлгүүдийн талаар явуулсан энэ бодлогын уршгаар дотроо хэдийгээр баян ба ядуугийн ялгаатай, түүнээс үүсвэрлэн гардаг зөрчил сөргөлдөөнтэй байсаар ирсэн ч гэсэн нутаг ус, аймаг хошуугаараа нэг доор хамтран аж төрж ирсэн, язгуур эрх ашгаараа нэгдмэл, цөөхөн монголчуудын хооронд сөргөлдөөн тэмцэл зохиомлоор хурцдаж, тэд өөр хоорондоо алан хядалцахад хүргэсэн байна. Өмч хөрөнгөө булаалгасан нийгмийн чинээлэг баян хэсэг, шашин шүтлэгээ доромжлуулж сүм хийдээ нураалгасан лам нарын гаргасан зүй ёсны эсэргүүцэл, тэмцлийг тоталитар төр тухайн үедээ хатуу дарж цээрлэснээр барахгүй тэрхүү бослого тэмцлийг хожим хойно нь гэм зэмгүй олон хүнийг хилсдүүлэн баривчлах, хардаж сэрдэх, алж хороох зорилгодоо аян шалтаг болгож ашигласан байна.

Төрийн аппарат иргэний нийгмийн хяналтнаас гарч хүнд сурталжих, ард олноос хөндийрэн хүнийсэх, аажимдаа цэрэгжих, цагдаажих явдал бол тоталитар төрийн шинж чанар байдаг. Анх нийгмийн дарлагдсан ядуу хэсгийн эрх ашгийг илэрхийлэн хамгаалах, хэрэгжүүлэх зорилго тавьж байгуулагдсан ардын нэртэй монголын төр 20-иод оны хоёрдугаар хагасаас эхэлж иргэний нийгмийн дээр нь гарч, түүний хараа хяналтыг үл ойшоон хүнд сурталжиж эхэлсэн байна. 1920-иод оны сүүлчээр зөвхөн төр биш, МАХН өөрөө ч хүнд сурталжсан, намын үйл ажиллагаанд ардчилал, шүүмжлэл, өөрийн шүүмжлэл боогдож хумигдсан, намын удирдлага, аппарат нь энгийн жирийн гишүүдээс хөндийрсэн байв.

Тийнхүү монгол оронд гарсан 1921 оны хувьсгалаас хойшхи 30-аад оны эхэн үе хүртлэх арав орчим жилийн хугацаанд нийгмийн амьдралын эдийн засаг, нийгэм, улс төрийн болон оюун санааны хүрээнд болсон томоохон үйл явдал, гарсан үзэгдэл, өөрчлөлт зэргийг улс төрийн ардчилал, хүний эрх, эрх чөлөө, төр ба иргэний нийгэм, бие хүний хоорондын харилцааны шинж чанарын үүднээс, өөрөөр хэлбэл улс төрийн дэглэмийн талаас нь авч үзэж дүгнэхэд манайд тоталитар дэглэмийн эх үүсвэр, үндэс суурь 1920-иод оны дунд үеэс эхэлж бүрэлдэн тавигджээ хэмээн үзэж болохоор байна.

Үндэс суурь, бүрдэл хэсгүүд нь тийнхүү бүрэлдсэн, туршилтын алхам, эхлэлээ хэсэгчилж хийчихсэн тоталитар дэглэмийн машин одоо өөрийнхөө хүч чадлаа нийгэмд харуулж, хүссэн санаснаа хийж биелүүлэх ёстой байв. Гэхдээ тоталитаризм өөрийнхөө мөн чанар, үнэн нүүр төрхөө нийгэмд хэзээд ч ил тод харуулж илчилдэггүй, үйлдсэн, үйлдэх гэм зэмээ ямар нэг үйл явдал, үзэгдлээр халхавчилж зөвтгөдөг, хүмүүст тийм байдлаар ухуулан итгүүлж хуурдаг байна. Тийм учраас тухайн үед Монголд бүрэлдэн тогтож буй тоталитар дэглэм жинхэнэ ёсоор бүрэн ажиллахад зохих шалтаг, шалтгаан, холбогдох нөхцөл байдал, хүчин зүйл бүрэлдсэн байх шаардлагатай байв. Чухамдаа тийм тохиромжтой нөхцөл байдал, хүчин зүйл монгол орны дотоод амьдралд ч, гадаад байдалд ч 1930-аад оны эхэн үеэс бүрэлдэн бий болж эхэлжээ. 1920-иод оны сүүлчээр МАХН-ын удирдлага, шийдвэрийн дагуу төрийн зүгээс феодал, лам нарын эсрэг нийгэм, эдийн засаг, улс төрийн хүчирхийллийн арга хэмжээг идэвхтэй явуулсан бөгөөд үүний хариуд олон тооны сүм хийдийн лам нар нам, төрийн хүчирхийлэл, хэт зүүний нугалаа, алдаа завхарлын эсрэг босож тэмцэл хийсэн байна. Түүнчлэн 1931—1932 онуудад язгууртан феодалууд энд тэнд мөн тийм бослого гаргаж эсэргүүцэн тэмцсэн юм. Феодал, лам нарын эдгээр бослого тэмцлийг зэвсэглэн дарсан бөгөөд энэ явцад гэм зэмтний зэрэгцээ гэмгүй үй олон хүмүүсийг хавтгайруулан шийтгэж хороожээ.

Монголын нийгмийн амьдрал дотооддоо дээрхи байдалтай, тайван тогтвортой биш байсан 1930-аад оны эхэн үед гадаад нөхцөл байдал нь дэлхий нийтийн амьдралд дайны аюул бодитойгоор тулгарч улс хоорондын харилцаа түгшүүртэй, хурцадмал болсон байв. Япон улс, 1935 оны эхээр Монгол улсын дорнод хилд довтолж Халхын сүмийн орчны нутаг дэвсгэрийг булаан эзэлжээ. Түүнчлэн Японы тал, нам төрийн хувьсгалт хүчирхийлэл, зүүний алдаа завхарлыг эсэргүүцэн тэмцсэн хэсэг бүлэг хүмүүсийг өөртөө татаж зорилгодоо ашиглах, монголын нутаг дэвсгэрт тагнан турших зэрэг үйл ажиллагаа явуулж байлаа. Энэ нөхцөлд нам, төрийн зүгээс улс орны батлан хамгаалах хүчин чадлыг бэхжүүлэх, цэрэг армийн байлдааны бэлэн байдлыг дээшлүүлэхэд ихээхэн анхаарч мөн бусад төрлийн зорилго чиглэлтэй арга хэмжээ авсан байна. Гэвч энэхүү зөв зүйтэй арга хэмжээний явцад төрийн байгууллага, удирдлагын аппарат цагдаажих, хувьсгалт сонор сэрэмжээ дээшлүүлэх нэрийн доор иргэд хөдөлмөрчдийг хардаж сэрдэх, тагнан турших, хувьсгалын эсэргүү, Японы талын хорлон сүйтгэгчид, тагнуул туршуулууд олширч идэвхтэй ажиллаж байгаа мэтээр дэвэргэж өөрийн ард олны эсрэг үйл ажиллагаа явуулахад хүрчээ.

Тийнхүү Монгол орны дотоод ба гадаадад 1930-аад оны эхний хагаст бүрэлдсэн ээдрээ бэрхшээлтэй, түгшүүртэй нөхцөл байдлын дам нөлөөгөөр, хамгийн гол нь ЗХУ-д энэ үед тогтон бэхжиж эрч хүчээ авсан сталины тоталитар дэглэмийн нөлөө шахалт, тэр нөлөөнд орсон нам төрийн удирдлагын хэт хувьсгалч, зүүний нугалаа, алдаа завхрал

бүхий үйл ажиллагаа, байдлыг хүнд бэрхшээлтэй дээр нь зохиомлоор улам хурцатгаж түгшүүртэй болгосон зэрэг нөхцөл шалтгаан, хүчин зүйлийн улмаас Монголын нийгэм 1930-аад оны дунд үе гэхэд бүхэлдээ тоталитар төрийн хардлага сэрдлэгийн бай болж хатуу хараа хяналт дэглэмд нь бүрэн оржээ.

Монголын нийгмийн шинэ түүхэнд тоталитар дэглэмийн үйлдсэн хамгийн аймшигтай гэмт үйлдэл болох 1937—1939 оны зохион байгуулалттай алан хядах үйл ажиллагаа буюу тэр үеийн хэллэгээр бол «нийтийн их дайчилгааны» талаар дурьдахгүй өнгөрч болохгүй. Ер нь тоталитар төр өөрийн орны иргэд, хүмүүсийг зохиомол, хилс хэргээр үй олноор нь зохион байгуулалттай, сонголт хийж алан хядаж шорон гянданд хорьж цөллөж байсан онцгой үзэгдлийг манайд төдийлөн нарийвчилж судлаагүй, бүрэн гүйцэд танин мэдээгүй байгаа. Энэ үзэгдэл бидний өнгөцхөн ойлгож заншсан шиг зүгээр нэг хувьсгалт хууль ёсыг зөрчсөн, нэг хүнийг тахин шүтсэн эсвэл хувийн хатуу харгис зан чанартай хэн нэг удирдагчаас болж үүсэн гарсан ердийн үзэгдэл биш, тун нарийн, тиймээс ч тал бүрээс нь хэд хэдэн салбар шинжлэх ухаа ны үүднээс судлан нэгтгэж дүгнэхийг шаардах асуудал юм.

1937 онд Улсын бага хурал, Сайд нарын Зөвлөлийн хавсарсан нууц тогтоолоор Дотоод явдлын яамны дэргэд улс төрийн хэрэгтнийг шүүн таслах Онцгой бүрэн эрхт комисс байгуулагдаж уг комиссыг Х.Чойбалсан толгойлох болжээ. Тийнхүү их аллага хядлагын бүх бэлтгэл хангагдаж, 1937 оны есдүгээр сараас эхэлж тэр үеийн Эрүүгийн хуулийн тусгай ангийн 42-45 дугаар зүйлд заасан эх орноосоо урваж, хувьсгалын эсэргүү ажиллагаа явуулсан гэх хэрэгт ял тулган хүмүүсийг үй олноор нь баривчилж эхэлсэн байна.

Манай оронд тоталитар төрийн үйлдсэн олныг хамарсан зохион байгуулалттай аллага хядлага 1933 оноос 1947 оны хооронд үргэлжилсэн гэж үзэж болох бөгөөд 1937—1939 онд дээд цэгтээ хүрчээ. Зөвхөн 1937-1939 онд хилс хэргээр баривчлагдсан 25785 хүнээс 20039 хүнд цаазаар авах, 5746 хүнд янз бүрийн хугацаагаар хорих ял тус тус ногдуулж эдлүүлсэн гэсэн мэдээ бий.²

Иргэд, хүмүүсийг хилс зохиомол хэргээр баривчлах, хууль бусаар шийтгэж цаазлах явдал урьд өмнөх үеийнх шиг олныг хамарсан байдалтай байхаа больсон ч гэсэн 1940-өөд оны эхэн үед хэсэгчилсэн байдлаар гарч байсан бөгөөд ардын дайсан байсаар байгаа, тэд эсэргүүцэл, тэмцэл, хорлон сүйтгэх үйл ажиллагаагаа улс төрийн хүрээнээс эдийн засгийн салбар луу чиглүүлэн төвлөрүүлэх болсон, тийм учраас хувьсгалт сонор сэрэмжээ дээд хэмжээнд хүргэсэн байх хэрэгтэй гэсэн үзэл ойлголт нам төрийн удирдлагын дотор бараг 40-өөд оны сүүлч үе хүртэл оршоор байсныг МАХН-ын 1947 онд хуралдсан XI их хурлын материалаас үзэж ойлгож болно. Ийм улбаа үндэстэйгээр 1947 онд маршал Чойбалсангийн амь насыг хорлохыг завдсан бүлэг буюу «Порт-Артурын хэрэг» гэгч сүүлчийн том зохиомол хилс хэргийг тоталитар төрийн улсыг аюулаас хамгаалах алба үүсгэн зохион байгуулж 80 хүнийг түүнд холбон баривчилснаас 42 хүнийг буудан алж үлдсэнийг нь шоронд хорьж зовоожээ.

Монгол дахь тоталитар дэглэм барагцаалбал 1930-аад оны дунд үе хуртэл товойж тодорсон удирдагч, хошуучлагчгүй шахам явж ирсэнээ 30-аад оны дунд үеэс гол нь гадаадын, сталинистуудын нөлөө дэмжлэгээр Х.Чойбалсан төр засгийн эрх мэдэлийн бүхий л өндөрлөгүүдийг гартаа төвлөрүүлж үлэмж эрх мэдэл, албан тушаалтай болж гарч иржээ.

Монгол орны хөгжлийн шинэ нөхцөлд цаашид бэхжин тогтож ноёрхсоор 1980-аад оны сүүлч үе хүрч нурсан тоталитар дэглэмийг түүний тэргүүн Ю.Цэдэнбалын үйл ажиллагаанаас салангид авч үзэх аргагүй юм.

1921 оны ардын хувьсгалын ялалт, түүний цаашдын гүнзгийрэлтийн ачаар урьд өмнө нь дарлагдан дарагдаж байсан нийгмийн хэсэг бүлгүүд эрх чөлөө, нийгмийн тэгш байдлыг олж өөрийн засаг төртэй болж түүнийг барилцах болсон билээ. Гэвч тийм ядуу хэсэг тус орны түүхэн хөгжлийн онцлогоос шалтгаалж эзэмшиж сурсан тодорхой боловсрол, эрдэм мэдлэггүй шахуу, улс төрийн соёл дорой, гэхдээ тэгш эрх, эрх чөлөөг хүссэн хэв маяг бүхий хүмүүс байсан нь тодорхой юм. Тэд хувьсгалын үр шимийг хүртэх тусам улс төрийн идэвх нь сэргэж аажимдаа хэт зүүний хувьсгалч шинж төрхтэй болсоор байсныг ажиглан харж болно. Хувьсгалт өөрчлөлтөнд өөрийнх нь боловсон хүчин, түшиг тулгуур, хэрэгжүүлэгчид шаардлагатай байдаг бөгөөд манайд тийм хувьсгалчид, хувьсгалыг гүнзгийрүүлэгчид дээрх шинж төрх, хэв маяг бүхий хүмүүс байв. Тэдний боловсрол, мэдлэг, улс төрийн соёлын түв шин доогуур байсны хоосон зайг чухамдаа хэт хувьсгалч, улс төрийн гэнэн бөгөөд нөгөө талаас балмад түрэмгий зан чанар нөхөж байлаа. Тэд эдгээр зан чанарынхаа улмаас хувьсгалын улаан тугийн доор улс төрийн тавцанд гарч ирдэг аль ч хүчний талд татагдан орох нь хялбар байсныг гадаадад сталинистууд, дотоодод хатуу чиг шугамтай монгол сталинистууд, овжин ашигласан юм. Эцсийн дүнд тэд өөрснөө хохирч хатуу харгисаар хууртагдсаныг 1930-аад оны төдийгүй дараагийн он жилүүдийн үйл явдлууд харуулсан билээ.

1940-өөд оны хоёрдугаар хагасаас Монгол улсын дотоод, гадаад нөхцөл байдал урьд өмнөх үеийнхээс өөр болж өөрчлөгджээ. Тоталитар дэглэм нийгмийг бүхэлд нь хатуу хянаж дэглэн дарангуйлсаар байсны зэрэгцээ нийгмийн амьдралын үндсэн хүрээ салбаруудад бий болсон шинэ нөхцөл байдал, гарсан өөрчлөлт, мөн гадаад орчны ч өөрчлөлтийг ямар нэг хэмжээгээр тусгаж өөрөө мөн хувьсаж барагцаалбал 1940-өөд оны сүүлч үеэс шинэ шинж, төлөв байдалтай болж өөрчлөлт хувьсгалын шинэ зааг үедээ аажим шилжин оржээ гэж үзэж болохоор байна.

Энэ үеийн, өөрөөр хэлбэл 1940-өөд оны сүүлч үеэс 1980-аад оны сүүлч үе хүртлэх хугацаанд монгол оронд оршин тогтсон тоталитар дэглэм өмнөх үеийнхээс хэд хэдэн онцлог шинжтэй байлаа. Юуны өмнө хүмүүсийг хилсээр баривчилж хууль бусаар алж хядах явдал арилж түүний оронд нийгмийн оюун санааны хүрээнд тавих хяналт нь хатуу хахир, хүчтэй болсон юм. Энэ үед улс орны амьдрал, хүмүүсийн боловсрол, соёлын түвшин, үзэл ухамсарт гарсан ахиц өөрчлөлтийн улмаас, түүнчлэн гадаад нөхцөл байдлын эрхээр шууд хядлага үйлдэх боломжгүй болсон бөгөөд ийм нөхцөлд хүмүүсийн бодол сэтгэлгээ, үзэл ухамсарт хүлэн барьж тоталитар дэглэмийг шүүмжлэхээс сэрэмжлэх нь чухал болсон байна. Тиймээс 1940-өөд оны сүүлч үеэс, тодруулбал 1947 оноос эхэлж нийгмийн оюун санааны амьдрал, нийгэм-улс төрийн сэтгэлгээ, уран сайхны соёл, урлаг, утга зохиол, сургалт боловсролыг тоталитаризмд тохирсон нэг хэв загвартай, халин гарч болохгүй нэг хүрээ хязгаартай байлгах, өөрөөр хэлбэл оюун санааны «террор» хийхэд нам, төрийн үйл ажиллагаа чиглэгдэх болов.

Тийнхүү тоталитар дэглэм монгол оронд хэсэгчилсэн байдлаар, аль нэг шинж илрэлээр биш, хэсэгхэн хугацаанд биш, чухамдаа бүхэл бүтнээрээ, хэдэн арван жилийн туршид тогтон ноёрхож, нийгмийг бүхэлд

нь хамарч, түүний хүрээ салбар тус бүрт өвөрмөц байдлаар нөлөөлөн илэрч байжээ. Энэ үүднээс үзвэл бидний өдий хүртэл бие биенээс нь салангид авч үзэж ирсэн, социализмын гажуудал гэж нэрлэж байсан үзэгдлүүд болох захиран тушаах арга, систем, нэг хүнийг тахин шүтэх ёс, нэг хүний ганцаар захирах, дарангуйлах ёс, бүдүүлэг тэгшитгэл, хуваарилалт, үзэл суртлын хатуу хяналт хязгаарлалт гэх зэрэг нь тоталитаризм хэмээх нэгдмэл нэгэн үзэгдлийн хоорондоо нягт холбоо хэлхээтэй илрэлүүд болох нь тодорхой болж байна.

Социализм нь нийгмийн байгуулал болохын хувьд улам бүр үндэс суурь нь ганхан суларч цаашдын зам нь мухардалд дөхөж очих тусам түүнд тохирсон улс төрийн дэглэм болох тоталитаризм мөн адил өөрийнхөө мөхөл сүйрлээ бэлтгэсээр байв. Гэхдээ ЗХУ дахь болон манай дахь тоталитар дэглэм хэрэв улс төрийн удирдлагад шинэ сэтгэлгээтэй хүмүүс гарч ирээгүйсэн бол бас л арваад жилээр тэсэж тогтсоор байх байсан. Тоталитаризм монголд сүйрэн нурах эсвэл цааш нь хувьсан өөрчлөгдөж бас л хэдэн арван жил тогтон наёрхсоор байх эсэх нь монголчуудаас биш, чухамдаа дэлхий дэх тоталитаризмын цайз бүхий Зөвлөлтийн их гүрэн дэх тоталитар дэглэм ямар байдалтай байхаас бүхэлдээ шалтгаалж байв. Зөвлөлт гүрэн дэх тоталитар дэглэм юуны өмнө өөрийнх нь эдийн засгийн бааз суурь гүнзгий хямарч ганхаж нурсанаас болж сүйрсэн юм. Зөвлөлт гүрэнд үүний улмаас болж өрнөсөн өөрчлөн байгуулалт манайд асар их нөлөө үзүүлж, нөгөө талаар тоталитар дэглэмийг урьд өмнөх үеийнхнээс арай гүнзгий, соргог байдлаар танин мэдэж түүний эсрэг эрс шийдвэртэй тэмцэх шинэ хүч зохион байгуулалттайгаар гарч ирж идэвхтэй хөдөлсөн зэрэг нөхцөл байдал, хүчин зүйл, түүнчлэн дотоод амьдралын зарим онцлог, нөхцөл байдлаас шалтгаалж манайд тоталитар дэглэм нурахдаа Европын зарим орных шиг биш, хурц тэмцэл, зэвсэгт мөргөлдөөнгүйгээр тайван замаар унажээ.

III

Хуучин социалист гэгдэж байсан улс орнуудад тоталитар дэглэм нурж унасны дараа дэлхий нийт болон тэдгээр орны хүн ард посттоталитаризм буюу тоталитаризмын дараах байдал гэж нэрлэж болохоор шинэ нөхцөл байдал, өвөрмөц үзэгдэлтэй тулгарч байна. Энэ нь монголын нийгэмд мөн адил хамаарч холбогдоно.

Манай оронд өрнөж буй улс төрийн ардчилал, зарлан тунхагласан хүний эрх, эрх чөлөөний эдийн засаг, нийгмийн үндсийг бүрдүүлэх явдал нэн чухал байна. Нийгэм зах зээлийн эдийн засагт шилжиж, урьдын нийгэм хангамжийн систем эвдрэн хүмүүсийн амьдралын түвшин доошлох хандлага нь шинэ сөрөг үзэгдлүүдийг бий болгож байна. Тэдгээрийн заримыг тоталитаризмын дараах нөхцөл байдлын аспектээр авч үзэж дурьдвал амьдралын түвшин доошлох тусам хүмүүсийн мэдэгдэхүйц тодорхой хэсэг нь тоталитаризмын үеийн тэгшитгэлд тулгуурласан амьдралын баталгаатай доод түвшинг хусэн санаад байна. Хэрэв улс төрийн ямар нэг хүч амьдралын минимум доод түвшинг баталгаатай хангах лоозон, амлалт, гаргаж улс төрийн тавцанд хүч түрэн гарч ирвэл нийгмийн тодорхой хэсэг давхраа тэдний талд татагдан орж болох юм.

Нийгмийн тодорхой хэсэг, ер нь өргөн давхраа өнөөгийн замбараагүй явдал, сахилга, хариуцлагын сулрал, гэмт хэргийн өсөлт, нийгмийн хэв журам, алдагдсаар байгаа аюултай сөрөг үзэгдэл, үйл явцаас зал-

хаж айдас түгшүүртэй болж хатуу гараар ч хамаагүй дэг журам тогтоож нийгмийн задрал бутралаас аврахыг ямар нэг хэмжээгээр хүсэмжлэх болсоныг нуух хэрэггүй.

Энэ нь нийгэмд хэв журам тогтоох, иргэд айх аюулгүй амгалан тайван аж төрж ажиллах нөхцөл бүрдүүлэх ам амлалт өгч түүний далим далбаан доор улс төрийн ямар нэг хүчин дахиад дарангуйлал тогтоох бодит боломжийг бий болгоод байна. Тийм үзэл санаа өвөрлөсөн улс төрийн нам, хүчин ч байгааг үгүйсгэж болохгүй билээ. Энэ бүхэн манай нийгэмд улс төрийн аль нэг хэлбэр хэмжээтэй дарангуй дэглэм тогтож болзошгүйг сануулж байгаа хэрэг. Тэгвэл улс төрийн тийм дарангуй дэглэм чухам ямар хэлбэрээр, хэрхэн яаж тогтож болох вэ? Түүнд түлхэц өгөх гадаад нөхцөл, хүчин зүйл бий юу? Эдгээр асуултанд хариу өгөх гэж оролдохдоо манайд тоталитар дэглэм урьд өмнөх хэлбэрээрээ, урьдын хүч нөлөөгөөрөө дахин тогтохгүй гэдгийг юуны өмнө хэлэх нь зүйтэй юм.

Хамгийн магадлалтай байж болох хувилбар бол улс орны эдийн засаг цаашид улам доройтож, улс төрийн хүчнүүд засгийн эрхийн төлөө хоорондоо тэмцэлдэн, нийгмийн амьдрал бүхэлдээ тогтворгүй байдалд орох, үүний улмаас гадаадын хөгжилтэй орнууд Монголыг сонирхохоо больж энэ бүх бэрхшээл, зөрчлийг одоо ч хуучинсаг хатуу чиг шугам баримталсаар байгаа улс төрийн тодорхой хүчин овжин ашиглаж, хоёр их хөршийн аль нэгнээс (ялангуяа Орос оронд коммунист дэглэм тогтвол) тус дэмжлэг авах замаар улс төрийн өөр, шинэ хэлбэр төрхтэй ноёрхол, дэглэм тогтоож болох хувилбар юм. Тийм дэглэм нь тоталитаризмыг бодвол авторитаризмд арай ойр төстэй байж болох талтай. Ардчиллалаас тоталитаризмд гулсан орох амархан, харин тоталитаризмаас ардчилалд шилжин орох нь хавьгүй хэцүү, зөрчил бэрхшээлтэй ажээ. Зах зээлийн зохицуулалттай эдийн засаг, ардчилалаас татгалзаж гэдрэг ухрахгүйгээр урагшаа алхах, тэр явцад тохиолдох бэрхшээл, зорилтыг Монголын өөрийнх нь өвөрмөц онцлог, түүнчлэн дэлхий нийтийн хөгжлийн хандлага, жишигийн алиныг ч харгалзан тооцох үндсэн дээр шийдвэрлэх, хэрэгжүүлэх шаардлагатай болоод байна.

Монгол орон бол уг нь дорнын орон. Өрнө, дорно гэдэг бол газар зүйн ойлголт болохоосоо соёл иргэншлийн утга агуулга нь давамгайлсан нийгэм-түүхийн ойлголт билээ. Энэ үүднээс тоталитаризмын дөнгөнөөс цаг хугацааны хувьд адилхан нэг үед мултран гарсан, өдгөө мөн адил тоталитаризмын дараах байдалд байгаа Дундад Азийн орнууд, тухайлбал Казахстаны туршлага, жишээ, түүнчлэн авторитар дэглэмийн хүрээнд харьцангуй богино хугацаанд хөгжил дэвшилд хүрч чадсан «Азийн бар» бvхий орнуудын туршлагыг тун анхааралтай судлан үзэх хэрэгтэй байна. Эдгээр орны туршлага нь тоталитар дэглэмийг нийгмийн болон улс төрийн субъектуулын дур зориг, эмх замбараагүй, дэг журамгүй, хариуцлага, сахилга батгүй явдалтай сольж болохгүйг, ардчилал, ба дэг журам, сахилга бат, хариуллага нь нэгдмэл байдгийг, энэ чанараараа ардчилал өөрөө улс төрийн өвөрмөц нэгэн дэглэм байдгийг харуулж байгааг ухаалгаар харж үзэж ойлгох, өөртөө тусгах хэрэгтэй юм.

1. Барууны орнуудад тоталитаризмын талаар нийтлэгдэн гарсан ном бvтээлийн тойм жагсаалтыг К. Г. Баллестрем. Апории теории тоталитаризма. Вопросы философии. 1992, № 5-д үзнэ үү.

* МАХН-ын Төв Хорооны Улс төрийн товчооны комисст. Үнэн. 1989, № 225